



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2025/007/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум
2025 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323833 Цахим хаяг: Khorloosuren.p.audit@gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: erdenetsetsegb@audit.gov.mn

Чадварлаг Аудит ХХК-ийн захирал: Д.Рэнцэнханд

Утас: 99200034 Цахим хаяг: chadvarlagAudit@gmail.com

Аудитор: П.Сосорбурам

Утас: 99016193 Цахим хаяг: sosorburampurev3@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 140
танай _____-ны № _____-т

“ӨВ.АГРО ГУРИЛ ТЭЖЭЭЛИЙН
ҮЙЛДВЭР” ОНӨ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Р.НАМГИЛРАГЧАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд борлуулалт 311.0 сая төгрөг, 336.8 сая төгрөгийн зардал гаргаж, 25.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК нь ертгөөр 337.8 сая төгрөгийн өвс хураан авч, 284.3 сая төгрөгийн өвс худалдаж 53.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2023 оны жилийн эцэст үлдсэн 17.4 сая төгрөгийн өвсийг ТУЗ-ийн 2024 оны 01 тоот шийдвэрийг үндэслэн акталж данснаас хассан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	713,965.00	827,541.00
1.1.2	Дансны авлага	63,500,000.00	15,967,760.00
1.1.6	Бараа материал	52,700,735.00	88,881,337.36
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	116,914,700.00	105,676,638.36
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	525,443,042.98	480,010,527.58
1.2.2	Биет бус хөрөнгө	350,402,147.95	350,269,786.31
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгө	875,845,190.93	830,280,313.89
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	992,759,890.93	935,956,952.25
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	78,799,080.00	78,799,080.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	108,018,188.00	77,018,188.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	186,817,269.00	155,817,269.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	186,817,269.00	155,817,269.00
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	707,841,295.10	707,841,295.10
2.3.9	Хуримтлагдсан ашиг	98,101,326.83	72,298,388.15
2.3.11	Эздийн өмчийн дүн	805,942,621.93	780,139,683.25
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	992,759,890.93	935,956,952.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	418,465,760.00	311,039,000.00
2	Борлуулалтын өртөг	363,563,152.00	284,291,105.64
3	Нийт ашиг (алдагдал)	54,902,608.00	26,747,894.36
8	Бусад орлого	9,912,000.00	11,897,600.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	47,971,375.91	45,564,877.04
11	Санхүүгийн зардал	2,007,468.00	1,511,900.00
12	Бусад зардал		17,371,656.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (14,835,764.09	-25,802,938.68
20	Татварын дараах ашиг (алдагдал)	14,835,764.09	-25,802,938.68
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	14,835,764.09	-25,802,938.68
24	Орлогын нийт дүн	14,835,764.09	-25,802,938.68
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Өвөрхангай аймгийн “Өв агро гурил,тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

төгрөгөөр

Мөри	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	348,742,360.00	303,778,840.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний	338,830,360.00	291,881,240.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	9,912,000.00	11,897,600.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	335,972,195.00	303,665,264.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	23,050,563.00	21,788,436.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,380,335.00	8,630,504.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	300,210,659.00	238,368,664.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,323,170.00	2,365,760.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,007,468.00	32,511,900.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн	12,770,165.00	113,576.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,250,000.00	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	17,250,000.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-17,250,000.00	0.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-4,479,835.00	113,576.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	5,193,800.00	713,965.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	713,965.00	827,541.00

2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх	707,841,295.10	83,265,562.74	791,106,857.84
2	Залруулсан үлдэгдэл	707,841,295.10	83,265,562.74	791,106,857.84
3	2023 оны 12-р сарын 31-ээрх	707,841,295.10	98,101,326.83	805,942,621.93
4	Залруулсан үлдэгдэл	707,841,295.10	98,101,326.83	805,942,621.93
5	Тайлант үеийн цэвэр ашиг (0.00	-25,802,938.68	-25,802,938.68
6	2024 оны 12-р сарын 31-ээрх	707,841,295.10	72,298,388.15	780,139,683.25

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

төгрөгөөр

Үзүүлэлтүүд	2024оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн болон нэмэгдэл цалин	25,373,733.00	29,383,421.00	4,009,688.00	115.80
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,171,716.63	4,460,404.25	1,288,687.63	140.63
Ариутгал	2,100,000.00	1,600,000.00	(500,000.00)	76.19
Тээвэр, шатахуун	56,250,000.00	64,078,004.00	7,828,004.00	113.92
Санхүүгийн зардал	1,042,000.00	1,511,900.00	469,900.00	145.10

Өвөрхангай аймгийн “Өв агро гурил,тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аж ахуйн материал	9,850,652.00	10,298,039.00	447,387.00	104.54
Газрын түрээс	35,062,500.00	36,662,500.00	1,600,000.00	104.56
Үрийн зардал	105,860,325.00	113,712,000.00	7,851,675.00	107.42
Сэлбэг хэрэгсэлийн зардал	4,500,000.00	12,019,000.00	7,519,000.00	267.09
Харуулын цалин	11,897,600.00	11,897,600.00	-	100.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		45,564,877.04	45,564,877.04	#DIV/0!
Бусад зардал		17,551,793.39	17,551,793.39	#DIV/0!
Байгууллагын нийт зардал	255,108,526.63	348,739,538.68	93,631,012.06	136.70
Борлуулалтын орлого	270,000,000.00	311,039,000.00	41,039,000.00	115.20
Харуулын цалингийн санхүүжилт	11,897,600.00	11,897,600.00	-	100.00
ОРЛОГЫН ДҮН	281,897,600.00	322,936,600.00	41,039,000.00	114.56
АШИГ+ АЛДАГДАЛ-	26,789,073.38	(25,802,938.68)	-	(96.32)

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17.4сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 17.4 сая төгрөгийн алдааг залруулав.

Аудитаар нийт 31.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж,14.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв .

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй.

3.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Замын хуудас, ажлын гүйцэтгэлгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй шатахууны зардал гаргаж, тооцоо бодохгүйгээр 627994.00 төгрөгийг зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэлт:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансны сайтад худалдан авсан 5904000.00 төгрөгийн шатахуун, 8848500.00 төгрөгийн тээврийн хөлсийг дутуу мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг цахим сайтад мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх, мэдээллийг бүрэн сайтад байршуулсан эсэхэд хяналт тавьж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг албан бичгээр нотлох баримтын хамт Төрийн аудитын газрын FAS системд 2025 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор оруулж илгээнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 2000 боодол 17371656.00 төгрөгийн 2023 оны өвсний үлдэгдэл чанарын шаардлага хангахгүй муудсанг ТУЗ-н 2024 оны	1	17,371.6			1	17,371.6	1	17,371.6				

Өвөрхангай аймгийн “Өв агро гурил,тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

10сарын 23-ны 01тоот шийдвэрийг үндэслэн акталсанг үйлдвэрлэлийн зардлын дансанд бичилт хийж зарлага гаргасан												
Дүн	1	17,371.6			1	17,371.6	1	17,371.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Замын хуудас, ажлын гүйцэтгэлгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй шатахууны зардал гаргаж, тооцоо бодохгүйгээр 627994.00 төгрөгийг зардалд бүртгэсэн байна.	1	628.0			1	628.0						
Дүн	1	628.0			1	628.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Өвөрхангай аймгийн “Өв агро гурил,тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тайлант онд шилэн дансны сайтад худалдан авсан 5904000.00 төгрөгийн шатахуун, 8848500.00 төгрөгийн тээврийн хөлсийг дутуу мэдээлсэн.	1	14,752.5						1	14,752.5
Дүн	1	14,752.5						1	14,752.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	1	14,752.5						1	14,752.5

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлагдтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ	1	1	0	0	1	0	0	0
	НИЙТ	1	1	0	0	1	0	0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

